



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/475

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №99 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 2 дахь заалтаар Хөвсгөл аймгийн прокурор (9070486)-ын Мөрөн сумын 8 дугаар багт байршилтай төрийн байгууллагын зориулалттайгаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээг 1385м² гэснийг 1464м² гэж өөрчилж үлдсэн 26 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан Мөрөн сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №99 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч Хөвсгөл аймгийн прокурор (9070486)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т, Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 011 11